



САНГИЙН
ЯАМ



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо:	2024 оны 12-р сарын 09-ний өдөр
Зээлийн дугаар ба нэр:	3313-MON: Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл
Гэрээний дугаар ба нэр:	БА3-2: АЛТАНБУЛАГ БООМТ ДАХЬ МАЛ, АМЬТНЫ ХОРИО ЦЭЭРИЙН БАЙГУУЛАМЖ
Тендер хүлээн авах эцсийн хугацаа:	2025 оны 01-р сарын 09-ний өдөр, 15:00 цаг (Улаанбаатарын цагаар)

1. Монгол улс Азийн Хөгжлийн Банк (цаашид “АХБ” гэх)-наас “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлэх зорилгоор зээл авсан ба энэхүү санхүүжилтийн тодорхой хэсгийг дээр дурдсан гэрээний хүрээнд хийгдэх төлбөрт ашиглана. Тендер шалгаруулалт нь АХБ-ны эрх бүхий орны харьяат тендерт оролцогчдод нээлттэй байна.

2. Сангийн Яам (цаашид “захиалагч” гэх) эрх бүхий тендерт оролцогчдоос *Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумд Мал, амьтны хорио цээрийн байгууламжийн барилга угсралтын* (цаашид “ажил” гэх) ажлыг барьж гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалтыг АХБ-ны дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалтын аргаар явуулна.

4. Зөвхөн доор дурдсан чадварын үндсэн шалгуур үзүүлэлтийг хангасан эрх бүхий тендерт оролцогч энэхүү тендер шалгаруулалтад оролцоно:

- Дараах үйл ажиллагааны барилгын ажлын туршлагатай байх, үүнд:
 - Барилгын нийт талбай нь 3,000м²-аас дээш, 90.00х54.4м-аас багагүй хэмжээтэй төмөр бетон арагт хийцэн, цутгамал төмөр бетон хучилттай барилга болон ачаа ачих/буулгах болон агуулахын талбайтай, автозам, нэвтрэх байр болон тээврийн хэрэгслийн ариутгах байр бүхий байгууламжийн барилгын ажил
 - 1.0М төмөр бетон ус зайлуулах хоолой бүхий 0.6 км-ээс багагүй урттай асфальтан замын ажил.
- Дараах санхүүгийн шалгуур үзүүлэлтийг хангасан байх, үүнд:
 - Сүүлийн 3 жилд амжилттай эсхүл үндсэнд нь гүйцэтгэж дуусгасан, мөн санал болгож буй ажилтай ижил төстэй нэгээс доошгүй гэрээт ажилд оролцсон байх, ингэхдээ тендерт оролцогчийн тухайн ажилд оролцсон ажлын үнэлгээ нь 9,500,000,000.00 /есөн тэрбум таван зуун сая/ төгрөгөөс доошгүй байх.
 - Сүүлийн 3 жилд /2021, 2022, 2023/ хэрэгжиж дууссан эсхүл хэрэгжиж байгаа гэрээт ажлын хүрээнд хүлээн авсан баталгаат төлбөрийн нийт дүнгээр тооцсон барилгын ажлын жилийн дундаж борлуулалтын доод хэмжээ нь 12,000,000,000.00 /Арван хоёр тэрбум/ төгрөг байх.
- Мөн, ажил гүйцэтгэхэд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөл, үүнд:
 - Барилга хот байгуулалтын яамны:
 - БА-3.1 Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил, эсхүл Хуучнаар: 2.1.3. Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн, барилгын ажил (1-9 давхар хүртэл);
 - БА-3.3 Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт; эсхүл хуучнаар: 2.2.3. Ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт;

- 1.3 БА-3.4 Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт; эсхүл хуучнаар: 2.2.4. Дулааны болон усан хангамжийн гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт;
- 1.4 БА-3.5 эсхүл БА-4.5 Цахилгаан дамжуулах шугам сүлжээ, дэд станц, түүний тоног төхөөрөмжийн угсралт;
- 1.5 БА-6.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт;
- 1.6 БА-6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж гадна салбар шугам сүлжээний угсралт; эсхүл хуучнаар: 2.2.1. Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт;
- 1.7 БА-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт;
- 1.8 БА-6.4 Барилга байгууламжийн дотор холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт; эсхүл хуучнаар: 2.2.2. Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, Холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт;
- 1.9 БА-7.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил;
2. Зам, тээврийн яамны:
 - 2.1 2.8.2.1.1 Хатуу хучилттай зам барих /асфальтан зам талбай/
 - 2.8.2.6 Авто машины зогсоол, талбайн тохижилтын ажил хийх, засварлах.

5. Сонирхсон тендерт оролцогч тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг дараах хаягаар авч болно.

Байгууллагын нэр: *Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл*

Гудамж/байр: *МН Тауэр, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж-15141,*

Давхар/өрөө: *14 давхар, 1404 тоот өрөө*

Аймаг/хот: *Улаанбаатар хот*

Улс: *Монгол Улс*

Цахим шуудан: spsproject.procurement@gmail.com; coordinator.spsproject@gmail.com

6. Эрх бүхий тендерт оролцогч тендерийн баримт бичгийг худалдан авахыг хүсвэл:

- **СВЗ-2: Алтанбулаг боомт дахь мал, амьтны хорио цээрийн байгууламжийн барилга угсралтын** ажлын тендерийн баримт бичиг авах хүсэлтийг дээр хаягийн дагуу бичгээр ирүүлнэ.
- Төсөл хэрэгжүүлэх нэгжийн дансанд **₮300,000** тэнцэх буцаан үл олгогдох хураамжийг дараах дансанд төлнө.
 - Дансны дугаар: 100900011843, Төрийн банк
 - Дансны нэр: УМЭАХАБХАХСТөсөл

7. Тендерийг дээр дурдсан хаягаар, тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө тендерийн баримт бичигт шаардсан тендерийн баталгааны хамт ирүүлнэ. Тендерийг тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссан даруйд тендерт оролцогчдын төлөөллийг (хэрэв тэд оролцохыг хүсвэл) байлцуулан нээнэ.